БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 22 өдөр Дугаар А/262 Булган сум

Аймгийн хэмжээнд 6 настай хүүхдийн
нүд, шүд, зүрхний эмгэгийн эрт илрүүлгийн үзлэг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 10.1.4, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.10, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.14 дэх заалт, Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын хамтарсан 2024 оны А/413, А/151 дүгээр тушаал, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны "Булганы сэргэлт хөтөлбөр"-ийг батлах тухай" IV/25 дугаар тогтоол, 2024 оны IV хуралдааны "Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай" IV/26 дугаар тогтоол, 2025 оны VI дугаар хуралдааны "Эрүүл Булган хөтөлбөр батлах тухай" VI/32 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд 6 настай хүүхдүүдийн нүд, шүд, зүрхний эмгэгийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгийг орон нутагт зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, хүүхдийн хараа шалгах үзлэг хийх сургуулийн багш, нийгмийн ажилтан, эмч нарыг чадваржуулах сургалтын удирдамжийг 2 дугаар, сургалтын хөтөлбөрийг 3 дугаар, дээрх үйл ажиллагаанд зарцуулагдах хөрөнгийн төсвийг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.Эрт илрүүлэг үзлэгийг аймгийн хэмжээнд зохион байгуулан, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг удирдлага арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (М.Батчимэг)-д даалгасугай.

3.Эрт илрүүлэг үзлэгийг эрүүл мэндийн байгууллагатай хамтран шуурхай зохион байгуулж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Дээрх үйл ажиллагаанд зарцуулагдах 3,727,000(гурван сая долоон зуун хорин долоон мянга) төгрөгийг хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Д.ГҮРЭВ-ОЧИР

Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010369

Аймгийн Засаг даргын 20.25 оны
04 дүгээр сарын 22-ны/ний өдрийн
А/262 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

Аймгийн хэмжээнд 6 настай хүүхдийн нүд, шүд, зүрхний эмгэгийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч: М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд:
П.Оюунцэцэг (Эрүүл мэндийн газрын дарга)
Ц.Цолмонбаатар (Боловсролын газрын дарга)
Б.Шижирбаатар (Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга)
Д.Нарантуяа (Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга)
Д.Отгонсүрэн (Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтсийн дарга)
Б.Урангаваа (Эрүүл мэндийн газрын Хяналт, шинжилгээ-үнэлгээний хэлтсийн дарга)
М.Солонго (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсролын бодлого хариуцсан мэргэжилтэн)
Б.Мөнхзул (Аймгийн шүдний эмч мэргэжилтнүүдийн холбооны тэргүүн)
Ж.Энхцогт (Боловсролын газрын Бага боловсрол хариуцсан ахлах арга зүйч)
Т.Ганчимэг (Боловсролын газрын Сургалтын орчин, хүүхдийн хоол үйлдвэрлэл үйлчилгээ хариуцсан ахлах арга зүйч)
Ерөнхий боловсролын сургуулийн захирлууд
Ерөнхий боловсролын сургуулийн эмч нар

Нарийн бичгийн дарга: М.Солонго (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн бодлого хариуцсан мэргэжилтэн)

Аймгийн Засаг даргын 2025 оны
04 дүгээр сарын 22-ны/ний өдрийн
А/262 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

Аймгийн хэмжээнд 6 настай хүүхдийн хараа шалгах
эрт илрүүлгийн үзлэг хийх сургуулийн багш, нийгмийн ажилтан,
эмч нарыг чадваржуулах сургалтын удирдамж

Зорилго:6 настай хүүхдүүдийн хараа шалгах эрт илрүүлэг үзлэгийг хийх боловсролын байгууллагын багш, ажилчдыг чадваржуулан бэлтгэх

Хамрах хүрээ:Булган аймгийн ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежер, эмч, эмчгүй сургуулиудын нийгмийн ажилтан 60 хүнийг хамруулна.

Хэзээ: 2025 оны 04 дүгээр сарын 24-25-ны өдөр

Хаана: Эрүүл мэндийн газрын сургалтын танхим

Үйл ажиллагаа:

1.Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын 2024 оны “Удирдамж батлах тухай” А/413, А151 дугаар хамтарсан тушаалыг танилцуулах

2.Эрт илрүүлэг үзлэгийн зохион байгуулалт, хамтрагч байгууллагуудын оролцоо

3.Харааны эмгэгтэй хүүхдийг дараагийн шатлалд илгээх журам, Эрүүл хүүхэд платформын танилцуулга

4.Сургуульд суурилсан харааны үзлэг, түгээмэл тохиолдох эмгэг

5.Хол, ойр, стерео хараа шалгах аргачлал, дадлага ажил

6.Сургуулийн эмч, нийгмийн ажилтан суралцагчид болон эцэг эх, асран хамгаалагчтай нүдний эрүүл мэндийн тухай хэрхэн ярих арга барил

7.Харааны эмгэг илэрсэн суралцагчдыг аймгийн Нэгдсэн эмнэлэгт илгээх ба хянахад анхаарах асуудал

Хүлээгдэж буй үр дүн:

Ерөнхий боловсролын сургуулийн эмч, нийгмийн ажилтан нар хүүхдийн хол, ойр, стерео харааг шалгах чадварыг бүрэн эзэмшсэн байна.

Аймгийн Засаг даргын 2025 оны
04 дүгээр сарын 22-ны/ний өдрийн
А/262 дугаар захирамжийн 3 дугаар хавсралт

Аймгийн хэмжээнд 6 настай хүүхдийн хараа шалгах
эрт илрүүлгийн үзлэг хийх сургуулийн багш, нийгмийн ажилтан, эмч
нарыг чадваржуулах сургалтын хөтөлбөр

Хугацаа	Үйл ажиллагаа	Чиглүүлэгч
1	2	3
Эхний өдрийн		
09:00-09:30	Бүртгэл	Зохион байгуулагч
09:30-09:55	6 настай хүүхдийн нүд, шүд, зүрхний эмгэгийн эрт илрүүлэг үзлэгийн нээлтийн үйл ажиллагаа	АЗДТГ-ын НБХ-ийн дарга М.Батчимэг, ЭМГ-ын дарга П.Оюунцэцэг, БГ-ын дарга Цолмонбаатар
09:55-10:00	Дурсгалын зураг	Зохион байгуулагчид
10:00-10:30	Эрт илрүүлэг үзлэгийн зохион байгуулалт, хамтрагч байгууллагын оролцоо	ЭМГ-ын НЭМХ-ийн мэргэжилтэн С.Ариунаа
10:30-11:00	Эрүүл хүүхэд платформын мэдээлэл, шивэлт хийх илгээх	АНЭ-ийн нүдний их эмч М.Давхарбаяр
11:00-11:20	Цайны завсарлага	
11:20-12:00	Сургуульд суурилсан харааны үзлэг, түгээмэл тохиолддог эмгэгүүд	АНЭ-ийн нүдний их эмч М.Давхарбаяр
12:00-12:30	Холын хараа шалгах аргачлал	АНЭ-ийн нүдний их эмч М.Давхарбаяр
12:30-13:00	Ойрын хараа шалгах аргачлал	АНЭ-ийн нүдний их эмч М.Давхарбаяр
13:00-14:00	Үдийн завсарлага	
14:00-14:30	Стерео хараа шалгах аргачлал	АНЭ-ийн нүдний их эмч М.Давхарбаяр
14:30-16:00	Холын хараа шалгах дадлага	АНЭ-ийн нүдний их эмч М.Давхарбаяр
16:00-16:20	Цайны завсарлага	
16:20-17:00	Асуулт, хариулт	Зохион байгуулагчид
2 дах өдрийн сургалт		
09:00-09:30	Бүртгэл	
09:30-10:00	Сургуулийн эмч, нийгмийн ажилтан суралцагчид болон эцэг эх, асран хамгаалагчтай нүдний эрүүл мэндийн тухай хэрхэн ярих арга барил	АНЭ-ийн нүдний их эмч М.Давхарбаяр
10:00-10:30	Дата цуглуулах кейс бүртгэх тухай	АНЭ-ийн нүдний их эмч М.Давхарбаяр
10:30-11:00	Харааны эмгэг илэрсэн суралцагчдыг АНЭ-т илгээхэд ба хянахад анхаарах асуудал	АНЭ-ийн нүдний их эмч М.Давхарбаяр
11:00-11:20	Цайны завсарлага	
11:20-13:00	Ойрын хараа шалгах дадлага ажил	АНЭ-ийн нүдний их эмч М.Давхарбаяр
13:00-14:00	Үдийн завсарлага	
14:00-16:00	Стерео хараа шалгах дадлага ажил	АНЭ-ийн нүдний их эмч М.Давхарбаяр
16:00-16:20	Цайны завсарлага	
16:20-17:20	Ярилцлага, асуулт, хариулт	Зохион байгуулагчид
17:20-17:40	Дүгнэлт, хаалт	Зохион байгуулагчид

Аймгийн Засаг даргын 2025 оны
04 дүгээр сарын 22-ны өдрийн
А/262 дугаар захирамжийн 4 дүгээр хавсралт

Аймгийн хэмжээнд 6 настай хүүхдийн хараа шалгах
эрт илрүүлгийн үзлэг хийх сургуулийн багш, нийгмийн ажилтан, эмч
нарыг чадваржуулах сургалтын төсөв

д/д	Шаардлагатай зардал	Хэмжих нэгж	Тоо	Үнэ (төгрөг)	
				Нэг бүр	Нийт
1	2	3	4	5	6
1	24/3 аяны баннер зардал	ш	4	282,750	1,131,000
2	Бичиг хэргийн багц	ш	5	20000	100,000
3	Өдрийн хоол	ш	130	18000	2,340,000
4	Цэвэр ус	ш	130	1200	156,000
	Нийт				**3,727,000**